



ОЮУ ТОЛГОЙН ХЯНАЛТ ТББ

2016-2017 оны Үйл ажиллагааны Тайлан

Оюу Толгойн Хяналт ТББ нь олборлох салбарын хүний эрх ба байгаль орчныг хамгаалах олон улсын зарчмууд ба стандартын нийцлийн хяналт мониторинг, эрхийг хамгаалах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий нийгэмд үйлчилдэг ашгийн бус байгууллага болно.

Үйл ажиллагаа эхэлсэн – 2009\10 сар

Бүртгэгдсэн – 2010\4 сар

ЭРХЭМ ЗОРИЛГО - ХҮНИЙ ЭРХ, АМЬДРАХ ОРЧНЫГ ХАМГААЛАХ

ЗОРИЛГО: Хөрөнгө оруулалт (ХО)-ын гэрээний нээлттэй байдал, хэрэгжилт, уурхайн олборлох ажиллагааг олон улсын хүний эрх, байгаль хамгаалах стандартад нийцүүлэх явцад хяналт тавих; тогтоогдсон зөрчлийг арилгуулахад нөлөөлөх; зөрчигдсэн эрхийн сэргээн эдлүүлэхэд нөлөөлөх.

ЗОРИЛТУУД:

- ✚ ХО-ын гэрээ Үндсэн хууль, олон улсын хүний эрх ба байгаль орчны эрх зүйд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэхэд нөлөөлөх
- ✚ ХО-ын гэрээний хүрэн дэх уурхайд хамаарах бүхий л үйл ажиллагааг хуулинд нийцүүлэх хяналт тавих, стандарт мөрдүүлэхэд нөлөөлөх
- ✚ Стратегийн орд газрыг ашиглах үйл ажиллагаанд нийцлийн мониторинг хийх механизм ба чадавх хөгжүүлэх
- ✚ Орон нутгийн иргэдийн, иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжих, чадавх бэхжүүлэх
- ✚ Олборлох компаниуд НҮБ-ын Бизнес ба Хүний Эрх Удирдамжийг хэрэгжүүлэхэд нийцлийн хяналт тавих чадавх хөгжүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛҮҮД:

- Оюу Толгойн ХО-ын гэрээг МУ-ын хууль, ОУ-ын хуулийн зарчмуудад нийцүүлэн өөрчлөхөд нөлөөлөх; ОУ-ын олборлох гэрээний зарчмын дагуу хяналтыг хэрэгжүүлэх чадавх хөгжүүлэх;
- Уурхайн ХО-ын гэрээний хэрэгжилт, олборлох ажиллагааны хууль, үндэсний ба олон улсын байгаль экологи, нийгмийн хамгааллын стандартад нийцлийн хяналт тавих, эрхийг хамгаалах;
- Тогтоогдсон зөрчлийг олон нийтэд мэдээлэх, арилгуулахад чиглэсэн бодлого\хуулийн шинэчлэлд санал өгөх; олон улсын, үндэсний гомдол барагдуулах хэрэгслүүдийг ашиглах; зөрчлийг арилгуулах бүх төрлийн нөлөөллийн хэрэгсэл ба аргачлал ашиглах;
- Хүний эрх, байгаль хамгааллын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын нөлөөллийн ажиллагааг хөгжүүлэх; ТББ-ын түншлэл хөгжүүлэх замаар чадавхыг бэхжүүлэх;
- Орон нутгийн бүлгүүд, иргэний нийгэмтэй харилцаа хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах; ОН-т хэвтээ түншлэл байгуулж туршлага солилцох, хүчээ нэгтгэхэд дэмжлэг үзүүлэх;
- Олон улсын иргэний нийгмийн сүлжээнүүдтэй босоо түншлэл байгуулж ОУСБ-аас баримтлах хүний эрх ба байгаль хамгаалах, нийгмийн хариуцлагын эрх зүйн орчинг сайжруулах нөлөөллийн ажиллагаанд оролцох;
- Хөрөнгө босгох төсөл боловсруулах, хэрэгжүүлэх.

ЭРХЭМ ЗОРИЛГО ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХУРААНГУЙ

Оюу Толгой Хяналт ТББ нь 2016-2017 онд эрхэм зорилгын хүрээнд *хүний эрх ба амьдрах орчныг хамгаалах* өргөн хүрээ бүхий үйл ажиллагаа хэрэгжүүлж ирсэн.

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг хэрэгжүүлэх явцад хүний эрх, байгаль орчны стандартын нийцэлд хяналт тавьж энэ хүрээний асуудлууд дотроос уламжлалт байгалийн нөөц буюу бэлчээр ба ус ашиглах эрхийг хангах үүргээ засаг төр ба компаниуд биелүүлж байгаа байдалд хяналт тавихад үйл ажиллагаагаа төвлөрүүлж ирсэн. Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний 6.19.2-т **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон усны нөөцийн талбайн хүрээнд энэхүү Гэрээг байгуулсан өдөр хэрэглэгдэж байгаа ундны болон мал аж ахуйн хэрэгцээний усны хэмжээ, чанарыг одоогийн хэмжээнээс бууруулахгүй байх. Мөн 6.10-т “Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа материаллаг сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол Хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ”** гэсэн заалтуудын хэрэгжилтэд хяналт тавихад нутгийн малчдад сургалт, зөвлөлгөө өгч ажиллаю. Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Нийцэл, Зөвлөлгөө ба Эрхийг хамгаалах албанд 2012-2013-нд гаргуулсан гомдлын хэлцэл үргэлжилж олон улсын хөндлөнгийн мэргэжлийн багаар хохирлыг нотлуулах ба үнэлүүлэхэд малчдын багт зөвлөлгөө өгч ажиллав. Мөн 2015 оны сүүлчээр Дубайн гэрээ байгуулагдсаны дараа Оюу Толгой төслийн 2-р шатны далд уурхайн барилгын ажлыг байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх знэлгээ хийлгэлгүй эхлүүлсэнтэй холботой нөлөөллийн ажил хийгдэж БОНБНУ-ний тодотгол нэртэй стандарт хангахгүй тайланг сэмээрхэн вебсайт дээрээ байрлуусан болсон.

Мөн 2016 онд Дорноговь (Улаанбадрах), Говь-Алтай (Цээл), Сэлэнгэ (Түнхэл) аймгуудад ажиглалт, баримтжуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. 2017 онд эхээр Багануурын уурхайн нөлөөлөл, шинээр барих ДЦС-ийн асуудал болон оны сүүлчээр Өмнөговь амьгийн Гурвантэс сумаас байгаль экологи ба хүний эрхийн зөрчлийн баримтжуулалт судалгаа хийх хүсэлт ирснийг хүлээн авч 2018 оны ажлын төлөвлөгөөнд оруулав.

2016-2017 онд нийцлийн хяналтын үйл ажиллагаа цар хүрээний хувьд тэлж хянаж ажиглах төслийн нэмэгдэхийн зэрэгцээ хянах зөрчлийн шинэ чиглэл **“эмэгтэйчүүдийн аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрх”**-ийн асуудал нэмэгдэв. Оюу Толгойн Хяналт ТББ-ын байгаль экологи ба хүний эрхийн хяналтын туршлагадаа үндэслэн **“байгалийн баялгийн ашиглах явцад зөрчигдөх эмэгтэйчүүдийн эрх, сөрөг нөлөөллийн ачаа охид, эмэгтэйчүүд дээр илүү бууж байгааг судалж хамгааллын орчин бүрдүүлэх нөлөөллийн ажил хийх”** төслийн санхүүжилтийн санал ирсний хүлээн авч хэрэгжүүлж эхэлсэн болно. Үүнд мөн гомдол боловсруулах, гомдол хүргүүлэх ба гомдлын хэлцлийн ажил гүйцэтгэснээр цаашид нутгийн хүн амын бэлчээр, газар ба өмчтэй байх эрх, цэвэр усаар хангагдах, охид эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлаа хангуулах эрхүүд зөрчигдөх, эрүүл аюулгүй орчинд амьдрах орчныг бохирдуулсны хариуцлага тооцоход бүхий л эрх зүйн орчин ба хууль хэрэгжүүлэх хэрэгслүүдийг ашиглан зөвлөлгөө авах, нөлөөлөхөд дэмжлэг авах нэхэлт орон нутгаас нутгийн бүлгүүдээс ирж үйл ажиллагааны чиглэл ба агуулга улам тэлж ирсэн. Энэхүү төсөл нь Жендер ба Ногоон акцийн Глобал альянс (Global Alliance for Green and Gender Action) олон улсын хөдөлгөөний нэгэн хэсэг болж хэрэгжиж байна.

Олборлох салбар, түүний дотор стратегийн орд газрын үйл ажиллагаанд **нийцлийн мониторинг хийх чадавхыг хөгжүүлэхэд** чиглэсэн үйл ажиллагаанд 2016-2017 онуудад нийцлийн мониторинг ба баримтжуулалт хэрхэн хийх, тогтоогдсон зөрчлийг арилгуулах талаар нөлөөллийн ажлын хэлбэр, аргачлалууд болон гомдол гаргахад нутгийн бүлгүүдийн бэлтгэл хангах, гомдлоо боловсруулах, компанитай хэлцэлд хэрхэн орох зэрэг практик дадлага, аргачлал өгөх сургалтуудыг давхардсан тоогоор нийт 400 орчим орон нутгийн иргэд болон ТББ-ын төлөөлөлд хийв.

Орон нутагт иргэний нийгэм, ТББ-ын хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Ханбогд сумын малчдын туршлагыг ижил төстэй нөлөөнд өртсөн болон өртөж болзошгүй самдын хүн амд малчдаар өөрсдөөр нь заалгаж түгээх сургалт 2 удаа Булган, Сэлэнгэд усан цахилгааны станцын газарт орж нүүлгэлтэд өртөх малчдыг оролцуулан хийв. Орон нутгийн ТББ-ыг дэмжихэд чиглэсэн олон улс, үндэсний болон орон нутгийн ТББ-ын босоо түншлэл хөгжүүлэх, орон нутгийн малчдын ТББ-ын хэвтээ түншлэл байгуулах ажлын эхлэлийг 2016 онд тавьж 2016-2017 онд Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сангаас нийт 6 жижиг төслийг 12 ТББ хэрэгжүүлэхээр татан төвлөрүүлж чадав.

Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг олон улсын стандартад нийцүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилтын хүрээнд 2017 онд Нидерландын Олон-талт компанийн судалгааны төв (SOMO)-тэй хамтран Оюу Толгойн ХО-ын гэрээнд татварын орчныг тогтворжуулснаар МУ-ын татвар ноогдуулж авах тусгаар эрх мэдлээс нь татгалзуулсан, давхар татварын гэрээнүүдэд гарын зсэг зуруулснаар мөн татвар зувчуулах боломжийг өөртөө бүрдүүлсэн асуудлаар судалгаа хийж зөвлөмж бүхий тайлан боловсруулсан нь 2018 1-р сард нийтэгдэнэ. 2016-2017 онд Ханбогд сумын малчдад хамаарах байгаль орчин ба нийгмийн заалтуудын хэрэгжилтийг хянах зорилгоор ХО-ын гэрээний заалтуудыг танилцуулах, мониторингийн ажилдаа баримтлах, Гурван талт зөвлөл (ГТЗ)-ийн хүрээнд ашиглах талаар зөвлөлөгөө өгөх, ОУ-ын стандартын гадаадын эскпертийн зөвлөлөгөө авах жижиг төсөл хэрэгжүүлэв.

Зорилтуудаа хэрэгжүүлэхэд **олон улсын сүлжээнд нэгдэх**, экспертуудыг татан оролцуулах болон энэ хүрээнд Дэлхийн Банк\ОУСК, ЕСБХБ, АХБ банкуудын Оюу Толгойд хөрөнгө оруулагч орнуудын засгийн газруудад нөлөөлөх ажиллагааг хангалттай хийж ирсэн нь үр дүнгээ өгч байна. Оюу Толгойн Хяналт ТББ нь дээрх банкуудын хянах олон улсын сүлжээнүүд, Хөгжил дэх Хүний эрх Сүлжээ, ЭЗХАХБ-ын Хянах сүлжээ, Азийн байгаль орчин, уур амьсгал болон хүний эрхийг хамгаалах бүсийн сүлжээнүүдтэй хамтран уурхай ба уурхайг дагасан дэд бүтцийн сөрөг нөлөөтэй тэмцэх асуудлуудаар хамтран ажиллаж ирсэн бол 2017 онд олон улсын хөндлөнгийн хариуцлагын механизм буюу хөгждийн банкуудын өөрийн гомдол барагдуулах механизмуудыг сайжруулах зорилго бүхий олон улсын иргэний нийгмийн ажлын хэсэгт орж ажиллав.

Мөн хүний эрхийг хамгаалах чиглэлийн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, бизнес ба хүний эрхийн бодлого боловсруулах сургалт, чадавх бэхжүүлэх арга хэмжээнд оролцож өөрийн чадавхыг нэмэгдүүлж УИХ, ЗГ-ын яамдад энэ асуудлаар асуулга тавих, бодлого боловсруулахыг шаардах ажлыг эхлүүлсэн. НҮБ-ын Хүний эрхийн хороотой хамтран ажилладаг сүлжээнүүдийн хүрээнд ажиллаж ирсэн. 2016-2017 онуудад “**Хөгжил дэх хүний эрх олон улсын сүлжээ**” хүрээнд олон-талт хөгждийн банкууд зээл олгох, компаниудад хөгжлийн банзуудын зээлээр төсөл хэрэгжүүлэхийн өмнө хүний эрхийн эрсдлийн үнэлгээ хийж байх зарчмуудыг боловсруулж Дэлхийн банзанп санал болгоход идэвхтэй оролцою. Хөгжлийн банкуудын

санхүүжилтээр хүний эрхийн зөрчилтэй үйл ажиллагаа явуулж буй төслүүдийг хаахыг шаардах олон улсын хөдөлгөөнд идэвхтэй оролцож ирэв.

ДҮГНЭЛТ:

Оюу Толгойн Хяналт ТББ нь 2010 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн долоон жилд олборлох салбарын мониторинг, хүний эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаанд улам тай ИНБ-ын хувьд олон улсын тавцанд ч, үндэсний болон орон нутгийн хэмжээнд ч **нэр хүндээ баталгаажуулж хүлээн зөвшөөрөгдөхөөс гадна идэвхтэй оролцогч болж томоохон арга хэмжээнүүдэд илтгэл тавих, судалгаанд оролцож, суудлаачид хүлээн зөвшөөрөх үр дүнд хүрсэн.**

Оюу Толгойн Хяналт ТББ зөвхөн ОТ-н мониторингоор үйл ажиллагааг хязгаарлахгүй байхыг шаардсан ИНБ-ын хүлээлтэд хариу болгон **хүчин чадлаа нэмэгдүүлэх** (ажилтан нэмж ажлын байр бий болгосон), үүний тулд **хөрөнгө босгох ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж** 2016-2017 нийт 63,000 мянган ам. долларыг өөрийн ТББ-ын үйл ажиллагаа болон байгаль орчин ба хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад найман (8) ТББ-ын үйл ажиллагааны зайлшгүй хэрэгцээнд зориулж татан төвлөрүүлсэн шинэ төрлийн үйл ажиллагааг эрхэлж эхлэв.

2017 оны 5-р сард ОУСК-ийн Нийцэл, Зөвлөх ба Эрхийг хамгаалах албанд 201-2013 онд гаргасан гомдлуудын зуучлал бүхий 5 жил үргэлжилсэн хэлцэл дуусч **Ханбогд сумын малчдын гомдлуудыг барагдуулах Гурван талт гэрээ** байгуулагдаж хэрэгжилтийн шатны ажил эхлэх, хэрэгжилтэд хяналт тавих, малчид ОТ-н усны хэрэглээ, айл тус бүртэй хийх гэрээний ажилд хяналт тавих шинэ төрлийн үйл ажиллагаа нэмэгдэх зэргээр тэдгээрийг гүйцэтгэх чадавх хөгжүүлэх шаардлага тавигдаж 2018 оны ажлын төлөвлөгөөнд орох шинэ ажил болов.

Олборлох салбарт **бизнес ба хүний эрхийг хамгаалахад чиглэсэн олон улсын нөлөөлөл, бодлого боловсруулах** үйл явцад оролцох, ТББ-дын хүрээнд олборлох салбарын олон улсын стандарт, НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн Удирдамжийн тайлагнал ба хариуцлагын шаардлагуудын тухай сургалт, мэдээлэл түгээх, байгаль орчин ба хүний эрх тайлангууд бичих, тайлангуудын дагуу НҮБ-аас Засгийн газарт ирсэн зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийх, хэрэгжилтийн эхлүүлэхийг шаардсан ч бизнесэд хариуцлага тооцох орчин бүрдүүлэх улс төрийн зориг ба сонирхол алга байгаа нь тодорхой байна.

Өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх **хөрөнгө босгох ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах** зорилго зорилтыг бүрэн хэрэгжүүлэхээс гадна үндэсний болон орон нутгийн ТББ-уудын хэвтээ болон босоо түншлэл хөгжүүлэх зорилгоор хөрөнгө босгож хүч хөрөнгөө бодитой нэгтгэсэн хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан хүлээгдээгүй үр дүнд гаргаж ажилласан нь 2018 онд улам баталгаажуулахад анхаарлаа төвлөрүүлэн ажиллах шинэ чиглэл болов.

2016-2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛААС

- Оюу Толгойн ХО-ын гэрээг МУ-ын хууль, ОУ-ын хуулийн зарчмуудад нийцсэн эсэхийг судлах, баримтжуулах

2017 онд Нидерландын Олон-талт компанийн судалгааны төв (SOMO)-тэй хамтран Оюу Толгойн ХО-ын гэрээнд татварын орчныг тогтворжуулснаар МУ-ын татвар ноогдуулж авах тусгаар эрх мэдлээс нь татгалзуулсан, давхар татварын гэрээнүүдэд гарын зсэг зуруулснаар мөн татвар зувчуулах боломжийг өөртөө бүрдүүлсэн асуудлаар судалгаа хийж зөвлөмж бүхий тайлан боловсруулсан нь 2018 оны 1-р сард нийтлэгдэнэ. Англи хэл дээрх тайланг <https://www.somo.nl/riotinto-taxschemes-mongolia/> татаж үзэж болно.

Оюу Толгойн төслийн 2-р шатны далд уурхайг санхүүжүүлэх үйл ажиллагааг ажиглах, хэлцлийн мэдээлэл цуглуулах, гэрээг өөрчлөх, шударга болгох, тогтворжуулалтын хугацааг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр УИХ, Засгийн газар, улс төрийн намуудын хүчин чармайлт, байр сууриудад судалгаа хийх, Дубайн гэх гэрээний зөрчлүүдийн талаар хэвлэлд мэдээллээр сонордуулах зэргээр нөлөөллийн ажил хийгдэж ирсэн. Мэдээллүүдийг манай www.minewatch.mn сайтаас татаж үзэж болно.

- Оюу Толгойн ХО-ын гэрээний хэрэгжилтэд нийцлийн хяналт тавих, эрхийг хамгаалах үйл ажиллагааныхаа чиглэлийн хүрээнд Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд амьдардаг малчдын уламжлалт усны нөөцөд сөргөөр нөлөөлсний улмаас ОТ-н 20 км орших усгүй болсон малчид өрхүүдийг зөөврийн усаар хангаж байгаад шийдвэр гаргах төрийн албад, олон нийтийн анхаарлыг хандуулах, усны нөөцийн үнэлгээ дахин хийлгэж зөрчлүүдийг тогтоолгох, ОТ компани, ЗДТГ ба гомдол гаргагчдын оролцоо бүхий Гурван Талт Зөвлөл (ГТЗ)-ийн хүрээнд Малчдын Төлөөлөл (МТ)-ийн усны мониторингийн ажлыг удирдах болон бусад мэргэжлийн мэдлэг шаардагдах тохиолдолд зөвлөх үйлчилгээ авах санхүүжилт босгох зэрэг ажиллаж гүйцэтгэв. Дэлхийн банкны групп (ДБГ)-ийн Олон улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ийн захирлуудад нутгийн хүн амын усны нөөцөд хохирол учруулсан асуудлаар Говийн газар шороо ТББ-ын гишүүн малчдын төлөөлөл болох Б. Эрдэнэбаярыг 2016 оны 4-р сард АНУ-д очиж гомдолтой байгаа мэдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ирсэн.

I. Зөрчлийг баримтжуулах, арилгуулах, эрхийг хамгаалах талаар:

Олон улсын байгаль орчин ба хүний эрхийн стандартад нийцээгүй үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах, нөлөөллийг бууруулах зорилгоор олон улсын шүүхийн бус гомдлын механизм хэрэглэх, эрхийг хамгаалах чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлсэн.

2014-2015 онуудад Ханбогд суманд гомдлын хэлцлийн үйл ажиллагаанд оролцох тухай бүрт Оюу Толгойн уурхайн лицензтэй талбай руу орж дотор үйл ажиллагаатай танилцах, холбогдох албаны ажилтнуудтай уулзаж мэдээлэл авах ажил тогтмол хийгдэж ирсэн. Үүнээс чухлаар ОТ-н ойр орчмоор явж уурхайн дэд бүтэц (усны лагуна, замууд, нисэх буудал ба түгээмэл тархацтой ашигт малтмалын карьер)-ийн нөлөөтэй танилцах, тогтоогдсон зөрчлийг арилгуулах шаардлагыг холбогдох албадад хүргүүлэх ажил тогтмол хийгдэж ирсэн. Зөрчлийг арилгуулахыг шаардсан гомдлуудын явцыг дор сийрүүлэв.

А. ОУСК-ийн гомдлын механизмд мэдүүлсэн гомдлын явц

2014-2015 онуудад Ундайн голын голдрилыг нутгийн малчдын эсэргүүцлийг үл харгалзан өөрчилснөөр малчдын усны нөөцөд хохирол учирсан эсэхийг тогтоолгох Хөндлөнгийн шинжээчид (Стив Баккли, Сабин Шмидт)-ийн үнэлгээний ажил хийлгэх ажлын даалгаврыг хэлцэж батлах, хөндлөнгийн шинжээчдийг шалгаруулан сонгох зэрэг ажлыг Гурван талт зөвлөлийн хүрээнд хийхэд нь зөвлөлгөө өгч ажилласан. Гурван тал зөвлөл байгуулах харилцан ойлголцлын санамж бичиг хэлэлцэж боловсруулах, ГТЗ-д малчдын дуу хоолой, шийдвэр гаргах эрх мэдэл нутгийн захиргаа болон ОТ компанийнхтай тэнцүү байхаар хэлэлцэж тохирох, ГТЗ-ийн Дүрэмд энэ эрх үүргийг хөдлөшгүй суулгаж ажлыг хийхэд гадаадын зөвлөхүүдийг татаж оролцуулах, зөвлөмжийг нь дамжуулах чухал үүрэг гүйцэтгэв.

ГТЗ-ийн үйл ажиллагааг жигдрүүлэх, малчид ГТЗ-ийн шийдвэр гаргах явцад бүрэн эрхтэй оролцох чадавхыг бий болгох зэрэг ажлуудад гадаадын зөвлөх татаж оролцуулах, энэ ажилд шаардагдах хөрөнгө босгох зэрэг ажлууд амжилттай хийгдэж ирсэн.

2015 оноос хохирол учирсан бүлэг малчдаас гадна Ханбогд сумын нийт малчдын амьжиргаанд ОТ-н уурхай хэрхэн нөлөөлснийг судлуулах хөндлөнгийн үнэлгээ хийлгэх асуудал дээр хэлцэл хийж тохирсон бөгөөд ажлын даалгавар хэлэлцэж эхэлсэн болно. Энэ Олон-талт шинжээчдийн багийн үнэлгээ нь малчдын хохирлыг нөхүүлэх, гомдлуудыг барагдуулахад чухал үүрэг бүхий зөвлөмж гаргуулах зорилготой 2016 оноос 4-5 хөндлөнгийн мэргэжилтний ажлын даалгавар боловсруулах, хэлэлцэж тохирох, сонгон шалгаруулалт хийж нийлбэр дүнгээр санал нэгтэй сонгох зарчмуудад үндэслэн хэрэгжих үнэлгээ юм. Гомдлын явц ба тайлангуудыг ОУСК-ийн САО-ийн вебсайт http://www.cao-ombudsman.org/cases/case_detail.aspx?id=191 англи, монгол хэл дээр татаж болно.

Б. Европын сэргээн босголт, хөгжлийн банк, ОУСК-д хамтад гаргасан гомдлын явц

1. Замын гомдол: ОТ-н орчмын замууд, Манлай -УБ замын тоос, дуу чимээ, аваар ослын улмаар нутгийн хүн ам болон мал сүрэгт учирсан эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн хохирол учруулсныг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны Төслийн гомдлын газар (ТГГ)-г гомдол гаргаж ОТ-г санхүүжүүлэгч ЕСБХБ, ОУСК-ийн гомдлын газрууд хоорондоо зохицуулалт хийж ТГГ-аас нийцлийн шалгалтыг хийхээр шийдэв. 2014-2015 туршид гомдол дээр нэмэлт мэдээлэл, тодруулга хийх, нийцлийг шалгагч хуульчидтай хэлцэл хийх, газар дээр ирж танилцах ажлыг зохион байгуулав.

ТГГ-ын дарга Эрика Бах, нийцлийн шинжээч Оуэн Мкинтайр нар 2015 оны 8-р сард Ханбогд суманд ирж газар дээрх байдалтай танилцаж явсан боловч нийцлийн хяналтын тайлангийн төсөл нь ч 2015 оныг дуусахад гараагүй байгаа нь гомдлын механизм процессийн хувьд зохистой ажиллах чадваргүй байгаагийн нэг илрэл байна. Нийцлийн тайлан хугацаанд гаргаж өгөөгүйгээс гадна компанийн болон ЕСБХБ-ны зээлийн асуудал эрхэлсэн багийн аясыг харах бололтой бөгөөд хараат бус тайлан гарч чадах нь эргэлзээтэй байна.

Оюу Толгойн ХХК өөрийн замуудын сөрөг нөлөөллийн талаарх гомдлыг өмнөх гомдлуудаас тусгайлан авч хэлэлцэхгүй, ГТЗ-ийн хүрээнд хэлэлцэж шийдэхээ мэдэгдсэн тул гомдлыг хэлцэлд оруулалгүй хаасан болно.

2. Говь-Алтай аймгийн Цээл суман дахь Алтайн хүдэр ХХК-ийн Таян нуур уурхайн нөлөөнд өртсөн нутгийн малчдын гомдлыг ЕСБХБ-ны ТГГ-т 2015 оны 1 дүгээр сард гаргуулан хөөцөлдөж Банкны удирдлагуудтай удаа дараа уулзсан ч зээлдэгч зээлдүүлэгч хоёрын харилцаа муудаж шүүхэд шилжих шатанд орж байгаа тул нутгийн малчдад учруулсан гомдлыг барагдуулах хэлцэлд орох боломжгүй гэсэн хариу өгсөөр ирэв. Нийцлийн хяналтыг хийлгэх талаар санал дэвшүүлж ямар нэгэн эцсийн шийдвэр гарахгүй явж ирсэн. Гомдлын талаарх мэдээллийг ЕСБХБ-ны ТГГ-ын сайтаас <http://igms-project.org/EN/database/EBRD/PCMcases.htm> татаж болно.

➤ Судалгаа, нийцлийн хяналтын үр дүнд үндэслэн олон нийтийн нөлөөллийн ажил, сургалт хийх

Судалгаа, нийцлийн хяналт мониторингоор илрүүлсэн асуудлуудыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, олон нийтэд мэдээлэх, нөлөөллийн зорилгоор дараах асуудлуудыг гаргаж тавьсан болно. Үүнд:

2014-2015 онуудад Ундайн гол, Халив-Дугат голуудын сав газар учирсан сөрөг нөлөөнөөс ширгэсэн, дундарсан булаг задгай, худгуудын судалгаа хийх ажлын даалгаварын үндэслэл гаргах зорилгоор газар дээр явж бүртгэл хийх ажлыг гүйцэтгэв. Мөн ОТ-н карьер ба бусад үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлын талаар хэлэлцэж хийэ хэлсэн газруудаар мониторингийн үзлэг зохион байгуулж ирсэн. Тогтоосон зөрчлийг арилгуулах нөлөөллийн ажлын хүрээнд Рио Тинто компанийн Лондон дахь дээд удирдлага, Оюу Толгой ХХК-ийн Монгол дахь удирдлага, МУ-ын ЗГ-ын холбогдох яам агентлагуудад хандан асуудал тавих, шийдлийг санал болгох, хэрэгжилтийг хянах зэргээр ажиллаж ирсэн.

3. Оюу Толгой, Таван Толгойн замууд, дэд бүтцийн барилгын хэрэгцээний карьеруудын зөвшөөрөл олгохдоо малчдын саналыг авахгүй, амьжиргааг нөхөхгүй, өргөдлийг шийдвэрлэхгүй сөрөг нөлөөлөл учруулж улмаар олон улсын стандарт зөрчиж байгааг баримтжуулж, малчдын гомдлын үндсэн дээр энэ асуудлаар ЗГ, орон нутаг болон Дэлхийн Банк, ЕСБХБ-нд анхааруулах, НҮБ-ын байгаль орчин ба хүний эрхийн асуудал эрхэлсэн албадад болон гадаад дотоодын ХМХ-ээр олон нийтэд хүргэх нөлөөллийн ажил хэрэгжүүлсэн.

Оюу Толгойгоос гадна Өмнөговь аймгийн Цогтцэций (Таван Толгой), Дорноговийн Хатанбулаг (хэд хэдэн уурхайн), Говь-Алтайн Цээл (Таян нуур), Сэлэнгэ аймгийн Мандал (Гацуурт) сумдад уурхайн сөрөг нөлөөллийн баримтжуулалтыг хийж асуудлуудыг үндэсний болон санхүүжүүлэгч банкуурын холбогдох албадуудад тавьж үндэсний болох олон улсын хэмжээнд бодлогын болон олон нийтийн нөлөөллийн ажил зохион байгуулав. Гзара дээр баримтжуулалт хийх аялалд Төв, Зүүн Европын Банк Хянах Сүлжээ, Нидерландын Үндэстэн дамнасан компанийн судалгааны төв, Бот Эндс, ХБНГУ-ын Үргевальд, Италийн Ри-Коммон, АНУ-ын Саутвест Судалгааны Төвийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллав.

МБОИЗ-ын Удирдах зөвлөлийн гишүүний хувьд орон нутгийн хяналт мониторинг, баримтжуулалтын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн Ногоон Сангийн жижиг тэтгэлэгээр санхүүжүүлэн агаар, газрын хөрс болон усанд цацраг идэвхтийн түвшин хэмжих, баримтжуулах, холбогдох газруудад хандаж яаралтай арга хэмжээ авахуулахад дадлагажуулах 5-н удаагийн сургалтын урааны хайгууль ба олборлолт бүхий аймгуудын төлөөлөл давтагдсан тоогоор нийт 125 хүнийг сургалтанд хамруулав. Орон нутагт уурхайн бохирдлын хяналт мониторинг хийхэд дутагдаж буй багаж хэрэгслээр хангах, мэдлэг чадварыг бий болгох

сургалтын хөтөлбөрийг энэ чиглэлээр тууштай ажиллах талуудыг олж хамруулахгүйгээс үр дүн муутай байна. Нэг сургалтанд суугаад сурсан зүйлээ ашиглан ямар нэг ажил зохион байгуулсан идэвхтэй ТББ ба хувь хүнийг шигжиж авч сургалтанд үргэлжлүүлэн хамруулах нь зүйтэй байна.

4. Төрийн бус байгууллагууд байгаль орчны хохирлыг нэхэмжлэх, нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрх олгогдох гэж байгаатай холбогдуулан нийтийн эрх ашиг нэхэмжлэх эрх зүйг судалж ирсэн.

Нөлөөллийн зорилгоор оролцсон олон улсын арга хэмжээ, хурал зөвлөлгөөн, тавьсан илтгэл ба гаргасан тайлангийн жагсаалтыг сонирхогч талууд тус байгууллагын вебсайт www.minewatch.mn -ээс татаж болно.

➤ Хүний эрх, байгаль хамгааллын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ нь үндэсний байгаль хамгаалах байгууллагуудын МБОИЗ-ийн гишүүн, хөгжлийн өргөн хүрээний асуудлуудаар ажилладаг ИНБ-ын МОНФЕМНЕТ сүлжээ, Хүний эрхийн ТББ-ын Форум зэрэг үндэсний иргэний нийгмийн байгууллагууд сүлжээний хүрээнд нягт хамтран ажилласан бөгөөд бөгөөд Хил хязгааргүй гол мөрөн (ХХГМ) бүсийн эвслийн гишүүний хувь Монгол дахь зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж эхэлсэн. Эдгээр сүлжээнүүдийн хүрээнд хамтарсан үйл ажиллагаа явуулж ирсэн тухай тайлангийн холбогдох хэсгүүдэд багтаасан болно.

➤ Хүний эрх, байгаль хамгааллын олон улсын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Хүний эрх, байгаль хамгаалагчийн эрхийг хамгаалах зорилгынхоо хүрээнд МГННХ-ний тэргүүн Ц. Мөнхбаяр нарын 7 хүний мөрдөн байцаах шат, шүүх хурдын үеэр эрхийг хангаж байгаа эсэх асуудлаар үндэсний болон олон улсын хүний эрх, байгаль хамгаалах сүлжээгээр дамжуулан нөлөөлөл хийх, байгаль хамгаалагч, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчин шаардагдаж байгаа асуудлуудаар УИХ, ЗГ болон олон улсын хяналт тавих байгууллагуудад хандаж ажиллаж ирэв.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR-ын хүрээнд МУ-ын Засгийн газарт НҮБ-ын байгууллагын гишүүн орнудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний ажлын хэсэгт орж ажиллах, “Уул уурхай –Байгаль орчин -Хүний эрх” чиглэлээр үндэсний болон олон улсын хурал зөвлөлгөөнд оролцох, олон нийтэд мэдээлэл ба сургалт түгээх, эрхийг хамгаалах механизмуудын сургалт түгээх, гомдол гаргуулах болон ул мөрөөр нь ХМХ-ээр нөлөөллийн ажил хийж ирэв.

➤ Орон нутгийн иргэний нийгэмтэй харилцаа хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах

1. Олон улсын байгаль орчин ба хүний эрхийг хамгаалах конвенц, стандартуудыг зөрчсөн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлэх шүүхийн бус механизмуудын талаар сургалт сурталчилгаа явуулах, гомдол гаргах бэлтгэл ажил, гомдол боловсруулах ба холбогдох газруудад гаргахад оролцох, гомдлыг барагдуулах эвлэрүүлэн зуучлах үйл явцад оролцох, малчдын бүлгүүдэд дэмжлэг үзүүлж ирсэн.
2. Малчдын бүлгүүд ТББ байгуулах, төсөл бичиж санхүүжилт авах, уурхайн нөлөөллийг томъёолж тайлбарлах, ТББ-ын хурал бэлтгэх, компани ба орон нутгийн захиргаатай уулзах, албан бичгээр харилцах, уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг мэдээлэх чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулсан.

3. Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай сумдын уурхайн нөлөөнд өртсөн малчдад давхардсан тоогоор 350 хүн, МБОИЗ-ын салбар зөвлөлийн гишүүд суманд нийт 125 хүнд 8 удаа очиж, 5 удаа Улаанбаатарт сургалт зохион байгуулж 14 удаагийн гомдлын хэлцэлд очиж оролцож ажилласан.



Зураг 2: Японы Сейса их сургуулийн профессор Цубоучитай хамтран орон нутагт цаираг идэвхтийн түвшин хэмжиж баримтжуулах, цаираг идэвхтийн хүн ба малын эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг таних, баримтжуулах сургалтыг 5 аймгийн төлөөлөлд хийж эхлэв.

➤ Хөрөнгө босгох төсөл боловсруулах, хэрэгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ-ын өөрийн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий хөрөнгийг GGF-ээс босгож чадаагүй нь 3 жил дараалан авсан тул өөртөө бус хамтран ажиллагчид авах байдлаар үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломж олгодог. Нийт 3 төслийн санал боловсруулж донор байгууллагуудад хандаж үүнээс 3 төслийн санхүүжилт авч хэрэгжүүлсэн болно. **Global Green Grants Fund (GGF)** – МБОИЗ-ын орон нутгийн салбаруудыг чадавхжуулах жижиг төсөлд 2015 оны 6 дугаар сард, 2014 ба 2015 онуудад жил дараалан Говийн газар шороо ТББ-ын малчдын төлөөлөлд зөвлөлгөө өгөх зорилготой жижиг төслийг мөн оны 5-р сард амжилттай гаргуулав.

Оюу Толгойн Хяналт ТББ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, хамтран ажиллах талаар бидэндтэй доорх хаягаар харилцаж болно.

Хаяг: СБД, Бага Тойруу, 44-204

Имэйл: otwatch@gmail.com

Гар: 976-98905828